



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 09 өдөр

Дугаар А/497

Булган

Аймгийн Засаг даргын дэргэдэх ахмад  
мэргэжилтнүүдийн зөвлөх баг  
байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", "б" заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэд эдийн засгийн гол салбар болсон хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар бодлогын зөвлөгөө өгөх, төсөл боловсруулах, зөвлөмж гаргахад мэргэжлийн түвшинд зөвлөн туслах зорилгоор ахмад мэргэжилтнүүдийн орон тооны бус зөвлөх баг байгуулж ажиллуулсугай.

2. Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн ахмад мэргэжилтнүүдийн зөвлөх багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, орон тооны бус зөвлөх багийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


3. Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн ахмад мэргэжилтнүүдийн орон тооны бус зөвлөх багийг ажиллах боломж нөхцөлөөр хангахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Б.Ууганбаяр/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

Аймгийн Засаг даргын 2017 оны  
09 дүгээр сарын 29 өдрийн 44-д тоот  
захирамжийн нэгдүгээр хавсралт



**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙН АХМАД МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН  
ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨХ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга: Ж.Даваа Агрономич  
Нарийн бичгийн дарга: Ч.Шүрэнцэцэг ХХААГ-ын мэргэжилтэн

Газар тариалангийн  
салбар:

П.Дамба	Инженер
Ц.Лхагвасүрэн	Инженер
Б.Цэрэн	Гавъяат агрономич
Т.Цэдэндамба	Гавъяат агрономич
Т.Жаргалант	Агрономич
Г.Эрдэнэбилэг	Агрономич
Ё.Нэргүй	Агрономич
Х.Гарнов	Агрономич
Т.Дамдин	Агрономич
Ш.Нямсүрэн	Агрономич

Малын аж ахуйн салбар:

О.Мэдэхгүй	Төрийн шагналт мал зүйч
Г.Алтангэрэл	Төрийн шагналт мал зүйч
Д.Дашбаяр	Мал зүйч
Г.Чулуундорж	Мал зүйч
Д.Баяраа	Мал зүйч
Г.Лхагвасүрэн	Малын эмч
Ч.Нарантунгалаг	Малын эмч
Б.Наранцогт	Малын эмч
Ц.Билэгтмаа	Малын эмч
Ж.Батчулуун	Малын эмч



Аймгийн Засаг даргын 2017 оны  
09 дүгээр сарын 21 өдрийн 134 тоот  
захирамжийн хоёрдугаар хавсралт

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭХЭД ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙН АХМАД МЭРГЭЖИЛНҮҮДИЙН  
ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨХ БАГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ**

**НЭГ. Нийтлэг үндэслэл:**

1.1. Аймгийн Засаг даргын дэргэдэх ХХАА-н ахмад мэргэжилтнүүдийн орон тооны бус озөвлөх баг /цаашид зөвлөх баг гэх/-ийн үндсэн зорилго нь аймгийн Засаг даргад эдийн засгийн гол салбар болсон хүнс, хөдөө аж ахуйн хөгжлийн талаар бодлого, чиглэл гаргахад зөвлөгөө өгөх, төрийн албаны уламжлал, мэргэжил, туршлагад тулгуурласан оновчтой санал, санаачлага гаргах, шаардлагатай үед малчид, тариаланчид, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд газар дээр нь заавар, зөвлөгөө өгч, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэхэд оршино.

1.2. Зөвлөх баг нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэх бөгөөд 21 хүртэлх хүний бүрэлдэхүүнтэй байна. Зөвлөх багийн нарийн бичгийн дарга нь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн байна. Зөвлөх багийн бүрэлдэхүүнд аймгийн мал аж ахуй, газар тариалангийн салбарт олон жил мэргэжилтэн, удирдах албан тушаал хашиж байсан олон жилийн ажил, мэргэжлийн туршлагатай ахмадын төлөөллийг оруулна.

1.3. Зөвлөх багийн дарга, гишүүд нь аймгийн Засаг даргын орон тооны бус зөвлөх байна.

1.4. Зөвлөх баг нь аливаа ажил, асуудлыг хуралдан хэлэлцэж, салбар бүрээр нь шийдвэр гаргах түвшинд зөвлөгөө өгч, санал, санаачлага гаргахдаа хууль, тогтоомжинд нийцсэн, холбогдох судалгаа, шинжилгээнд тулгуурласан байна.

1.5. Зөвлөх багийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд бүх гишүүдийн 51-ээс дээш хувь нь ирсэн буюу саналаа ирүүлснээр хүчин төгөлдөр болно. Түүнчлэн биечлэн зөвлөгөө өгөх, салбар, салбараар тусгайлан хуралдаж саналаа нэгтгэж өгөх зэрэг болно.

1.6. Зөвлөх багийн хуралдаанаас гаргах шийдвэр нь зөвлөмж байна.

### **ХОЁР. Зөвлөх багийн хүлээх үүрэг:**

2.1. Зөвлөх багийн дарга, гишүүд нь хуралдаанд идэвх санаачлагатай оролцож өөрийн биеэр санал, дүгнэлт гаргана. Хуралдаанд оролцож чадахгүй онцгой тохиолдолд зөвлөх багийн дарга, нарийн бичгийн даргад мэдэгдэж, санал дүгнэлтээ албан ёсоор бичгээр ирүүлсэн байна.

2.2. Аливаа ажил, асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой тооцоо, судалгааг холбогдох мэргэжлийн байгууллагаас гаргуулж авсан байна.

2.3. Шийдвэр гаргах түвшинд заавар, зөвлөгөөг өгөхдөө цаг үеийг мэдэрсэн, төрийн уламжлалыг хадгалсан, ажил, мэргэжлийн туршлагаар батлагдсан байх шаардлагыг хангасан байна.

2.4. Зөвлөх багийн дарга нь аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд урилгаар суух тохиолдолд өөрийн биеэр ирж оролцох ба түүний эзгүйд зөвлөх багийн аль нэг гишүүн оролцоно.

### **ГУРАВ. Засаг даргын Тамгын газрын хүлээх үүрэг:**

3.1. Зөвлөх багийг биечлэн уулзах боломж нөхцлөөр тухай бүр хангах.

3.2. Зөвлөх багийг хуралдах үед өрөө тасалгаа, бусад техник хэрэгслэлээр хангана.

3.3. Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд асуудлыг хэлэлцүүлэх тохиолдолд урилгаар оролцох боломж нөхцлийг хангана.

3.4. Аливаа ажил, асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой шаардлагатай мэдээ, мэдээллээр хангана.

3.5. Хөдөө ажиллах тохиолдолд унаагаар хангана.

### **ДӨРӨВ. Бусад зохицуулалт:**

4.1. Зөвлөх багийн бүрэлдэхүүнийг батлахдаа аймгийн Засаг даргын захирамжаар батлах бөгөөд гишүүдийг дахин томилох тохиолдолд зөвлөх багийн даргын саналыг үндэслэн аймгийн Засаг дарга шийдвэрлэнэ.

4.2. Зөвлөх багийн даргыг бүх гишүүдийн хурлаас 4 жилийн хугацаатай сонгоно.